



## ДОТООД ХЯНАЛТЫН ЗААВАР

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү баримт бичгийг Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексийн хүрээнд нээлттэй хувьцаат компанийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлэн боловсруулсан болно.
- 1.2 Энэхүү баримт бичгийн зорилго нь “Гермес Центр” ХК /цаашид “компани” гэх/-ийн үйл ажиллагаа нь хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмын дагуу явагдаж байгаа эсэх, санхүүгийн мэдээллийн үнэн зөв байдлыг хангахад чиглэсэн нягтлан шалгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### Хоёр. Дотоод хяналт

- 2.1 Дотоод хяналт гэж хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмын нийцтэй байдал, санхүүгийн мэдээллийн үнэн зөв байдлыг нягтлах, хяналт шалгалтын үйл ажиллагааг ойлгоно.
- 2.2 Компани нь бүхий л түвшинд эрсдэлд суурилсан дотоод хяналтын үйл ажиллагааг явуулах бөгөөд дотоод хяналт нь дараах чиглэлтэй байна. Үүнд:
  - 2.2.1 Компанийн хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн биелэлт болон нийцэлд хяналт тавих
  - 2.2.2 Нөөцийн ашиглалтын үр ашигтай болон үр дүнтэй эсэхэд хяналт тавих
  - 2.2.3 Үйл ажиллагааны болон санхүүгийн тайлагналын үнэн зөв байдалд хяналт тавих,
  - 2.2.4 Эрсдэлийг үр ашигтай удирдаж байгаа эсэхэд хяналт тавих,

### Гурав. Дотоод хяналтын зарчим

- 3.1 Дотоод хяналтыг гүйцэтгэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:
  - 3.1.1 Хуулийг дээдлэх: хяналт шалгалтын үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулах
  - 3.1.2 Хараат бус байх: төв голч, шударга хандлагатай байж, сонирхлын зөрчлөөс ангид хараат бус байх
  - 3.1.3 Шударга байх: шалгалтанд хамрагдаж буй аливаа алба хэлтэс, нэгжид шударга хандахын зэрэгцээ хяналт, шалгалттай холбоотой асуудлаар тайлбар гаргах эрхээр хангах
  - 3.1.4 Бодитой байх: хяналт, шалгалтанд аливаа хөндлөнгийн зүйлд автахгүйгээр зөвхөн хуулийн хүрээнд ажилладаг байх,
  - 3.1.5 Мэргэжлийн ур чадвартай байх: харилцааны болон мэргэжлийн ур чадварыг эзэмшсэн байх
  - 3.1.6 Тэгш хандах: шалгуулагч бүрт адил нөхцөл байдалд ижил хандах
  - 3.1.7 Нууцыг хадгалдаг байх: өөрийн үүргээ гүйцэтгэхээс бусад тохиолдолд шалгуулагчийн талаарх мэдээллийг задруулахгүй байх
  - 3.1.8 Туслалцаа үзүүлдэг байх: хууль тогтоомжийн талаар зөвлөгөө, туслалцаа үзүүлдэг байх
  - 3.1.9 Хөндлөнгийн байх: дотоод хяналтын үйл ажиллагааг явуулахдаа хөндлөнгийн байр сууринаас хандах

### Дөрөв. Дотоод хяналтын үйл явц

- 4.1 Дотоод хяналтын үйл явц нь дараах үе шаттайгаар хэрэгжинэ. Үүнд:
  - 4.1.1 Хяналтын орчныг бүрдүүлэх
  - 4.1.2 Эрсдэлийн үнэлгээ хийх
  - 4.1.3 Хяналтын үйл ажиллагаа явуулах

- 4.1.4 Мэдээлэл, харилцаа холбоог зохистой ашиглах
- 4.1.5 Хяналт, мониторинг хийх
- 4.1.6 Тайлагнах

#### Тав. Дотоод хяналтын хэрэгжүүлэлт

- 5.1 Дотоод хяналтыг компанийн гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.
- 5.2 ТУЗ нь дараах байдлаар дотоод хяналтын үйл ажиллагааг хариуцана.
  - 5.2.1 Дотоод хяналтын бодлогыг тодорхойлох, батлах, түүнийг өөрчлөн сайжруулах,
  - 5.2.2 ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороогоор дамжуулан дотоод хяналтын үйл ажиллагаанд хяналт тавина.
- 5.3 Гүйцэтгэх захирал нь дараах байдлаар дотоод хяналтын үйл ажиллагааг хариуцана.
  - 5.3.1 Дотоод хяналтын бодлогын дагуу дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, түүний ажиллах журам, зарчим, дүрмийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх
  - 5.3.2 Дотоод хяналтын төлөвлөгөөг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх
  - 5.3.3 Дотоод хяналтын албаны ажлыг дүгнэх
- 5.4 Дотоод хяналтын алба нь дараах байдлаар дотоод хяналтын үйл ажиллагааг хариуцана.
  - 5.4.1 Дотоод хяналтын үйл ажиллагааг хууль, тогтоомж, батлагдсан бодлого, дүрэм, журам, стандартын дагуу гүйцэтгэх
  - 5.4.2 Компанийн өндөр эрсдэлтэй хэсгүүдэд чиглэн ажиллах
  - 5.4.3 Дотоод аудитын үйл ажиллагааны тайланг гүйцэтгэх захиралд тайлагнах

#### Зургаа. Хяналт, сайжруулалт, өөрчлөлт оруулах

- 6.1 Дотоод аудитын хорооноос хяналтын үйл ажиллагаанд аудит хийж түүнээс гаргасан үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийн дагуу дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулна.
- 6.2 Дотоод аудитын хорооноос гаргасан дүгнэлт, зөвлөмж, ТУЗ, түүний дэргэдэх Аудитын хороо, гүйцэтгэх захирлын саналд үндэслэн дотоод хяналтын бодлогод өөрчлөлт оруулж болно.

#### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ